



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

додой оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/210

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн
орлогыг зарцуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215, тогтоолын хавсралтын 4 дүгээр хэсгийн, 4.1.1, 4.1.4, 4.1.6, 4.1.8, 4.1.9 дэх заалт, Цэргийн албаны хуулийн 31 зүйлийн 31.6, 31.7, 31.8 заалт, Нийслэлийн Засаг даргын А/1379 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 2024 онд нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн мөнгөн төлбөрийн орлогын хувийг батлагдсан хууль, тогтоомж дүрэм журмын хүрээнд Цэргийн штабын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлэх, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, Батлан хамгаалах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдахаар зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

2.Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр худалдан авах эд хэрэгслийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Мөнгөн төлбөрийн зарцуулалтын тайланг тогтоосон хугацаанд гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхийг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т, бараа материалыг Тамгын газрын орлого, данс бүртгэлд авахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү), нярав (П.Дэлгэр) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

1123200554

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 дугаар сарын 12 ны өдрийн
8720 дугаар захирамжийн хавсралт



ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ МӨНГӨН ТӨЛБӨРӨӨР
ХУДАЛДАН АВАХ ЭД ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТАД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

д/д	Худалдан авах шаардлагатай бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Каск (орон нутгийн хамгаалалтын сургалт)	34	45.000	1,530,000
2	Хантааз агсамж (орон нутгийн хамгаалалтын сургалт)	34	70.000	2.380,000
3	Котель	34	45.000	1,530,000
4	Ширээ, сандал (албаны)	1 хос	560,000	560,000
Нийт:				6.000.000